

ТЯНЬЖИН ХОТ

Н.ТӨМӨР*

Тяньжин хот нь БНХАУ-ын 3 дахь том хот /Бээжин, Шанхайн дараа/ бөгөөд 11.9 мян. хав. дөр. км талбайтай, 2010 оны байдлаар 12.938 сая хүн амтай, 3 сян, 13 дүүрэгтэй. ДНБ-ний нийт хэмжээ нь 2010 оны байдлаар 922.446 тэрбум юаньд хүрч, нэг хүнд ноогдох хэмжээ нь 70.402 мян. юань болжээ. БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн 2006 оны 3 дугаар сарын 22-ны шийдвэрээр Тяньжин хот "Бохайн бүс нутгийн эдийн засгийн төв, олон улсын боомт хот" болов.

Тяньжин хотын бүс нь Хайхэ голын эргийн дагуу байрлана. Тяньжин нь хойд, урд, баруун талаараа Хэбэй мужтай хиллэн, зүүн талаасаа Номхойн далайн Бохайн булангаар хүрээлэгдэнэ. Тяньжин хот Бээжингээс 100 орчим км-д орших бөгөөд хоёр хотын хооронд өндөр хурдны авто болон төмөр замаар холбогдсон. Тяньжин хот нь эх газрын уур амьсгалтай бөгөөд дөрвөн улиралтай, өвөл хүйтэн салхитай байх ба зундаа халуун, чийглэг бороотой, хавар хуурай, салхитай байх ба зарим үед шороон шуурга болно. Жилийн дундаж температур 13.2°C байна.

Улаанбаатар, Тяньжин хоёр хотын хооронд 1992 оны 9 дүгээр сарын 27-нд найрсаг харилцаа тогтоож, эдийн засаг, худалдаа болон бусад холбогдол бүхий салбарт хамтран ажиллаж, тухайлбал, Тяньжин хотын уран

бүтээлчдийн тоглолт Улаанбаатарт олон удаа болов. Улаанбаатар, Тяньжин чиглэлд 2010 оны 11 дүгээр сараас нислэг хийж эхэлсэн бөгөөд уг чиглэлд 98 зочигчийн E-190 загварын нисэх онгоц долоо хоногт хоёр удаа нислэг хийдэг байна. Тяньжиний Иргэний агаарын тээвэр сайн хөгжсөн. Тяньжин нь Шанхай, Шэньжэнь, Гуанжоу, Гонконг, Чэнду, Чунчин, Харбин, Хөххот, Куньмин, Сямэнь, Чиндао зэрэг Хятадын томоохон хотууд руу өдөр бүр шууд нислэгтэй байхаас гадна Сөүл, Нагоя зэрэг хот руу мөн тогтмол нислэгээр үйлчилж байна. Тяньжиний олон улсын онгоцны буудал хотын төвөөс 13 км зайтай.

Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр 2009 онд Тяньжин хотод айлчлан, ХКН-ын Төв хорооны Улс төрийн товчооны гишүүн, Тяньжин хотын намын хорооны дарга Жан Гаоли, хотын дарга Хуан Синго нартай уулзалт хийсэн. Уулзалтын үеэр хоёр тал Монгол Улс, БНХАУ-ын найрамдалт харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх талаар ярилцан, Монгол Улсын Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам, БНХАУ-ын Тяньжин хотын Ардын Засгийн газартай Тяньжин хотын Бинхай шинэ дүүргийн бүс нутагт хоёр талын эдийн засаг, худалдааны хамтын

* Н.ТӨМӨР- ШУА-ийн ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх тухай протоколд гарын үсэг зурсан юм. Монгол, Хятадын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор үйл ажиллагаа явуулах "Улаанбаатар төлөөлөгчийн газар"-ыг Тяньжинд байгуулан 2009 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. "Улаанбаатар төлөөлөгчийн газар" нь Тяньжин хотын Бинхай шинэ дүүргийн Дунзяны гаалийн баталгаат боомт бүсийн захиргаатай харилцан тохирч тус гаалийн баталгаат боомт бүсэд дор дурдсан чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар тогтсон. Үүнд: тээвэр ложистикийн хамтарсан компани байгуулах, улмаар тээвэр ложистикийн төв байгуулах., жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ /хөнгөн үйлдвэрлэл, сав баглаа боодол/ явуулах, мах, махан бүтээгдэхүүн болон хүнсний бүтээгдэхүүнийг хадгалах, дамжуулан борлуулах, улмаар хөргүүлтэй агуулахын аж ахуй байгуулах зэрэг асуудлыг ярилцан шийдвэрлэснээс гадна уул уурхайн боомт бүс болох Наньзяны боомтод түүхий газрын тос хадгалах, борлуулах, коксжих нүүрс хадгалах, борлуулах зэрэг асуудлын талаар мөн хэлэлцэж тохиролцов.

Тяньжин хот нь БНХАУ-ын хойд хэсгийн хамгийн том тэнгисийн боомтыг түшиглэсэн эдийн засгийн нээлттэй хот. Тяньжин хот нь 19-р зууны дунд үеэс үйлдвэр худалдааны боомт хот болон хөгжсөнөөр Хятад улсын хойд хэсгийн санхүү эдийн засаг, худалдаа бизнесийн томоохон төв нь болжээ. 2000 орчим жилийн түүхтэй Тяньжин хотын үүсэл хөгжил нь м.э.ө 5-р зуунд байгуулагдсан Хөх мөрөн, Хатан гол, Хайхэ гол, Хуэйхэ гол, Чяньтан мөрөн зэрэг 5 мөрөн голыг холбосон, 1801 км урт бүхий Хятадын их

суваг буюу Бээжин-Ханжоугийн суваг дээр орших байрлалтай салшгүй холбоотой. Уг байрлал нь Тяньжин хотод хөгжих таатай нөхцлийг бүрдүүлсэн. Тухайн үед Бээжин-Ханжоугийн сувгаар дамжин Хятадын өмнөд нутагт үйлвэрлэсэн аж үйлдвэрийн бараа болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн Бээжин рүү тасралтгүй зөөн тээвэрлэн, тээвэрлэгдэх бараа ачааны хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэж байсан тухай хятадын түүх сурвалж бичигт тэмдэглэсэн байдаг. Эдүгээ Тяньжин хот нь Хятад улсын томоохон усан боомт хотуудын нэг болж, дэлхийн 180 гаруй орны 500 гаруй усан боомттой харилцаа тогтоож хамтран ажиллаж байна. Тяньжин хотын боомтын нийт талбайн хэмжээ 260 хав. дөр. км, үүнд хуурай газрын талбайн хэмжээ 72 хав. дөр. км бөгөөд усан хөлөг онгоцны 94 зогсоолтой. Тяньжин хот дээрх давуу талыг ашиглан гадаад худалдааг ихээхэн хөгжүүлэн, 2009 оны байдлаар түүний гадаад худалдааны нийт хэмжээ 63.944 тэрбум ам.долларт хүрч үүнээс экспорт 29.985 тэрбум ам.доллар, импорт 33.959 тэрбум ам.долларт хүрсэн. Тяньжин хотын газар нутагт одоогийн байдлаар алт, вольфрам, молибден, зэс, цайр, төмөр, марганец, бор, усан болор, гантиг, газрын тос, байгалийн хий зэрэг төмөрлөг, төмөрлөг бус болон эрчим хүчний үүсвэрийн 20 гаруй төрлийн байгалийн нөөц баялаг илэрсэн. Газрын тосны /нөөцийн нийт хэмжээ 4 тэрбум тонн/ болон байгалийн хийн /нөөцийн нийт хэмжээ 150 тэрбум шоо метр/ асар их нөөцтэй байгаа нь тус хотын эдийн засгийн цаашдын хөгжилд эерэг нөлөө үзүүлэх нь дамжиггүй. Тяньжин хотын газар тариалангийн талбайн хэмжээ 185.609 гектар бөгөөд энэ нь тус хотын нийт газар нутгийн

40.7 хувийг эзэлдэг.

Тяньжин хот нь машин механизм, эрчим хүч, газрын тосыг боловсруулах, хими, цахим мэдээллийн бичил хэрэгсэл, тоног төхөөрөмж, компьютер, цахилгаан бараа, өргөн хэрэгцээний бараа зэрэг бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх олон аж үйлдвэртэй бөгөөд сайн чанарын ган хоолой, ган хийц болон чанар сайтай төмөрлөгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэлээд хөгжжээ. Хятадулсын анхны телевизор, анхны телефон аппарат, анхны гэрэл зургийн аппарат, авто машины анхны хөдөлгүүр, анхны бугуйн цаг зэрэг бүтээгдэхүүн Тяньжинд үйлдвэрлэн гаргасан байдаг. Дэлхийн 500 нэртэй пүүс компанийн 143 нь Тяньжинд салбар компани болон төлөөлөгчийн газраа нээн ажиллуулж байна. 2006 онд Бинхай шинэ дүүрэгт аэробус А320 нисэх онгоц угсрах үйлдвэр барьж байгуулсан нь Франц, Герман хоёр улсын дараа Хятад улс энэхүү нисэх онгоц угсардаг дэлхийн 3 дахь орон болов.

Тяньжин хотод 2010 оны байдлаар Тяньжиний их сургууль, Нанькайн их сургууль, Анагаах ухааны их сургууль, Багшийн их сургууль, Аж үйлдвэрийн их сургууль, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Санхүү эдийн засгийн их сургууль, Худалдааны их сургууль, Гадаад хэлний их сургууль, Хөдөө аж ахуйн их сургууль зэрэг 19 их дээд сургуультай. Тяньжиний их дээд сургуулиудад нийт 133.1 мян. оюутан суралцаж, 28.1 мян. тусгай мэргэжлийн профессор, багш нар ажилладаг. Тяньжиний их сургууль нь 1895 онд байгуулагдсан Хятад улсын нэрт их сургуулиудын нэг юм. Тус их сургууль нийгмийн ухаан, тоо физик, аж үйлдвэр, эдийн засаг, цахим мэдээлэл, нарийн

машин мехнизм, хими биологи, удирдахуйн ухаан, хууль зүй, сурган хүмүүжүүлэх ухаан зэрэг 51 мэргэжил бүхий 15 дээд сургуультай. Нанькайн их сургууль 1919 онд байгуулагдаж, нийгэм болон байгалийн ухааны 18 дээд сургуультай. Тус сургуульд нийт 10762 оюутан суралцахаас гадна, 4046 магистрант, 1609 докторант, 847 гадаадын оюутан тус тус суралцдаг.

Тяньжин хотод түүх соёлын дурсгалт газрууд олон байдаг. Үүнд: бурхны шашны Дулэси хийд, христийн Ванхайлоу сүм, Дагукоу боомтын их бууны тавцан, Цагаан хэрэм дээрх Хуаняагуан цайз багтах бөгөөд тус хотын түүхийн дурсгалт газрууд болон музей үзэсгэлэнд нийтдээ 53 мянга шахам түүхийн ховор нандин бүтээл хадгалагдаж байна.

Тяньжин хот нь өөрийн үндэсний өвөрмөц дүр төрх бүхий байшин барилга, гүүр, гудамж талбайгаас гадна англи, герман, итали, франц, орос, грекийн эртний сонгодог загварын байшин барилга ихтэй. Тухайлбал, Марко Пологийн талбай, Дагуанминь гүүр, Ванхайлоу, Сикай христийн сүмүүдийн барилга байгууламжийг дурдаж болно. Европ загварын энэхүү барилгуудыг "Бяцхан европ" хэмээн нэрлэдэг аж. Үндэсний уламжлалт болон европ загварын барилга хосолсон учир тяньжинчүүд төрөлх хотоо "түмэн улсын барилгын үзэсгэлэн" гэж нэрлэдэг ажээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1. Tianjin 2010 Basic Facts, China Intercontinental Press, Beijing, 2010
2. Tianjin impression, Tianjin, 2009
3. 中国, 外文出版社, 北京, 2009
4. 天津日报 2009.04.16
5. 中国辞典, 五洲传播出版社, 北京, 2008
6. 天津滨海新区的成长与展望, 天津社会科学院出版社, 天津, 2008
7. <http://www.ubtg.gov.mn>
8. <http://baike.baiu.com>

"ӨНӨӨ
Хя
хятад
эм, э
тасрал
нэгтгэ
тогтсо
арга
юм. Х
гэдэг
ерөнх
үндэс
анагаа
ухаан,
4 үндэ
Уламя
үндэс
үсэг
нь нэ
анагаа
дахин
ХИ
улсаар
хойш
"Хята
эмнэл
ухаан
Хя
Хя
үндэс
түүхт
* Г.ОН